



ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 10 өдөр

Дугаар 4/04

Бор-Өндөр сум

Өмч хамгаалах байнгын зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 15 дугаар тогтоолын хавсралт, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны арван нэгдүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгө хадгалалт, хамгаалалт, ашиглалтад байнгын хяналт тавих үүрэг бүхий өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Гишүүд:


Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн

Хүйх 5 дугаар багийн Зохион байгуулагч

2. Засаг даргын Тамгын газрын хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшил, ашиглалтад байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллахыг өмч хамгаалах байнгын зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



З.УУГАНЖАРГАЛ

D:/bichig hereg/Тушаал.docx